



ТУСГАЙ ДУГААР

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АР ТАЛЫН ТҮҮХТ 100 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН МЭНДИЙГ ӨРГӨН ДЭВШҮҮЛЬЕ!

МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм генерал, офицер, ахлагч, ажилтан албан хаагч, бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмад дайчид Та бүхэнд Зэвсэгт хүчний Ар талын түүхт 100 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье!

Нэгэн зууны тэртээгээс Ардын Засгийн газраас Цэргийн яамны бүтцэд “Бэлтгэлийн хэлтэс”-ийг байгуулсан бөгөөд түүхэн хөгжлийн явцад Бүх цэргийн бэлтгэлийн газар, Ардын цэргийн хэрэг эрхлэх яамны Арын албаныг Удирдах газар, Монголын Ардын Армийн Ар талыг удирдах газар, ЗХЖШ-ын Цэргийн хангалт, үйлчилгээний газар, Ар талын газар, Материал,

техникийн газар хэмээх нэрийн дор Зэвсэгт хүчний Материал, техникийн хангалт, үйлчилгээг тасралтгүй, найдвартай явуулж байна.

Өнгөрсөн 100 жилийн хугацаанд Зэвсэгт хүчний Материал, техникийн мэргэжлийн бие бүрэлдэхүүн нь Монгол Улсын төр, засгаас болон цэргийн дээд командлал, Зэвсэгт хүчнээс хүлээлгэсэн үүргийг нэр төртэй биелүүлж, 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны Чөлөөлөх дайны хүнд хэцүү нөхцөлд материал, техник, зэвсэг, галт хэрэглэлийн хангалтыг тасралтгүй зохион байгуулсны зэрэгцээ улс орны хөгжил дэвшил,

бүтээн байгуулалт, даян дэлхийн энхийн үйлсэд ч жинтэй хувь нэмэр оруулсныг бид цаг ямагт бахархан дурсаж байдаг юм.

Түүнчлэн Улсын батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх, Зэвсэгт хүчний материал, техникийн бэлэн байдлыг хангах, Зэвсэгт хүчний материал, техникийн бүх шатны нэгжийн үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлж, цэргийн сургалт бэлтгэлийг тасралтгүй явуулах боломжоор хангах, бие бүрэлдэхүүний ажиллаж, амьдрах ая тухтай орчныг бүрдүүлэх, материал, техникийн хангалт, үйлчилгээний чанар, хүртээмжийг

дээшлүүлэх чиглэлээрх бүтээлч санаачилгууд дэмжигдэн, Батлан хамгаалах аж үйлдвэрийн суурь тавигдаж, эхнээсээ үр дүнгээ өгч байна.

Нэгэн зууны хугацаанд ар талын хангалтын тогтолцоог бэхжүүлэх, хөгжүүлэх үйлсэд залуу халуун нас, мэдлэг, дадлага, чадвараа харамгүй зориулан ажилласан үе үеийн ахмад дайчид, өнөөдөр Зэвсэгт хүчний материал, техникийн хангалт, үйлчилгээг тасралтгүй явуулж байгаа мэргэжил нэгт дайчин нөхөд, Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүнд түүхт баярын мэндийг өргөн дэвшүүлье.

Монгол цэргийн сүр хүч, сүлд хийморь үеийн үед мандан бадрах болтугай!
ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН МАТЕРИАЛ, ТЕХНИКИЙН ГАЗРЫН ДАРГА БРИГАДЫН ГЕНЕРАЛ М.МӨНХБАЯР

“АМЬДРАЛ ТЭЭСЭН АР ТАЛЫНХАН” ЧУУЛЖ БАЙНА

Тус хуралд ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг, ЗХЖШ-ын Материал, техникийн газрын дарга бригадын генерал М.Мөнхбаяр, Батлан хамгаалахын сайдын зөвлөх дэслэгч генерал Ц.Дашзэвэг, БХЯ-ны ХШУДАГ-ын дарга, хурандаа Б.Эрхэмбаяр болон ар талын албаны үе үеийн ахмадууд, ажилтан албан хаагчид оролцож байна.

“Зэвсэгт хүчний ар тал-100” ойн баярын арга хэмжээг ЗХЖШ-ын Материал, техникийн газрын дарга бригадын генерал М.Мөнхбаяр нээсний дараа ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг “Цэрэг хаана бид тэнд хэмээх эрхэм уриатай Та бүгдийн хичээл зүтгэлээр Зэвсэгт хүчний материал, техникийн хангалтын тогтолцоог боловсронгуй болгон, Зэвсэгт хүчний цэргийн сургалт бэлтгэлийг тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлж, материал, техникийн бүх төрлийн хангалт, үйлчилгээг

тасралтгүй явуулахын зэрэгцээ ажиллаж амьдрах аятай орчныг бүрдүүлэх, бие бүрэлдэхүүний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлд зорилго, зорилтуудаа тодорхойлж, багагүй арга хэмжээг хэрэгжүүлж, түүхт ойгоо ажлын бахдам амжилт, арвин бүтээлтэйгээр ийнхүү ёслол төгөлдөр тэмдэглэж буйд туйлын баяртай байна. Энэхүү амжилт бүтээлийн эх сурвалж нь үе үеийн ахмад буурлуудын маань алсыг харсан холч мэргэн ухаан, уйгагүй, бүтээлч хөдөлмөр, зүтгэл, эх орноо гэсэн нэгэн үзүүрт сэтгэл, эвийг эрхэмлэсэн үйл ажиллагааны үр дүн гэдгийг түүхт ойн баярын хурлын хүндэт индрээс бахархан дурсаад, Та бүхэндээ эрүүл энх, аз жаргал, сайн сайхны дээдийг өрөөе. Та бүхний залгамж халааг үргэлжлүүлэн Зэвсэгт хүчний өмнө тавигдсан зорилго, зорилтуудыг амжилттай хэрэгжүүлж байгаа ЗХЖШ-ын Материал, техникийн

газар, харьяа ангиуд, Зэвсэгт хүчний материал, техникийн бүх шатны нэгжүүдэд ажиллаж байгаа “Ар тал”-аар овоглогдсон бие бүрэлдэхүүндээ түүхт ойн баярын мэндчилгээг өргөн дэвшүүлж, ажлын амжилт, сайн сайхныг хүсэн өрөөе” хэмээн мэндчилгээ дэвшүүллээ.

Түүхт ойн баярын хурлын хүрээнд Зэвсэгт хүчинд нэвтрээд буй зэвсэг техникийн үзэсгэлэн, харьяа анги, байгууллагын танилцуулга зэргийг дэлгэн сурталчилж байна. Мөн энэ үеэр Батлан хамгаалахын сайдын тушаалаар шагнагдсан тэргүүний алба хаагчдад салбарын шагнал гардуулахаас гадна “Зэвсэгт хүчний ар тал-100” сэдэвт эсээ бичлэгийн уралдаанд шалгарсан бүтээлийн эздэд ч шагнал гардуулах юм. Түүнчлэн ЦДБЭЧ болон Ар талын ангиудын уран сайханчдын хамтарсан “Амьдрал тээсэн Ар талынхан” хүндэтгэлийн тоглолтыг толилуулах юм.



АЖЛЫН ХЭСЭГ ГОВИЙН БҮСЭД ...

Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнайгаар ахлуулсан ажлын хэсгийн ээлжит томилголт энэ удаа говийн бүсэд үргэлжилж байна. Тодруулбал, орчин

бие бүрэлдэхүүний үйл ажиллагаатай танилцсаны дараа тэдэнтэй уулзалт хийв. Энэ үеэр үндсэн үүргийнхээ хажуугаар зундаа хүнсний болон

чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх спорт заалыг сэргээн засварлах хөрөнгө мөнгө санхүүгийн асуудлыг судалж шийдвэрлэж өгөхийг салбарын захирагч, дэд хурандаа С.Мөнхжаргал салбарын удирдлагуудаас хүссэн юм.

Уулзалтын төгсгөлд эрхэлсэн ажил албандаа итгэл зүтгэлтэй ажилласан зарим алба хаагчдыг Батлан хамгаалахын сайдын тушаалаар “Дайчин алдар” медаль, “Эх орны төлөө” хүндэт тэмдгээр шагнасныг гардуулсан юм. Үргэлжлүүлэн ажлын хэсэг Зэвсэгт хүчний 336 дугаар ангид ажиллалаа. Ажлын хэсгийг тус ангийн захирагч хурандаа А.Болдбаатар болон ангийн бие бүрэлдэхүүн хүлээн авч хүндэтгэл үзүүлсний дараа ангийн товч танилцуулга, барилга байгууламжтай танилцсан юм. Тус анги ирэх онд түүхт 90 жилийнхээ ойтой золгох бөгөөд ангийн



үеийн хэв маяг, инженерийн шийдэл бүхий стандартын шаардлага хангасан жишиг “Цэргийн хотхон” төслийн хүрээнд говийн бүсэд байрлах Зэвсэгт хүчний анги, салбаруудад ажиллаж тэдгээрийн үйл ажиллагаа, барилга байгууламжийн байдалтай танилцан тулгамдсан асуудал, санал хүсэлтүүдийг шийдвэрлэн ажиллаж байна.

Үүний зэрэгцээ УОК-ын даргын 65 дугаар тушаалын дагуу Өмнөговь, Дундговь аймгийн ард иргэдийг коронвируст цар тахлын халдварын эсрэг дархлаа сэргээх нэмэлт тунд хамруулах ажлыг эрчимтэй зохион байгуулан ажиллах юм.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн өчигдөр Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 281 дүгээр байгууламж болон ард түмнийхээ дунд “Их говийн гарнизон” хэмээн алдаршсан Зэвсэгт хүчний 336 дугаар ангид ажиллалаа. Ажлын хэсэг монгол орны зүүн болон

нарийн ногоо тариалж, ангийн байлдааны жижүүрлэлтийн үүрэг гүйцэтгэх алба хаагчдын хоолны нөөцийг хангадгийг



ажлын хэсэг сайшаасан юм. Мөн салбарын тухайд Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлаж байсан ОХУ-ын цэргийн ангийн барилга байгууламжийг түшиглэн ажиллаж байгаа учир барилга байгууламжуудын дээвэр

ой, Зэвсэгт хүчний 100, Батлан хамгаалах яамны 110 жилийн түүхт ойг угтаж өөрсдийн дотоод нөөц боломждоо тулгуурлан чамлахааргүй бүтээлч ажлуудыг өрнүүлжээ. Үүний дотор ангийн цэргийн гал тогоог сэргээн засварласан, цэргийн халуун усны тоног төхөөрөмж, талхан цехийг шинэчилж сайжруулсан, зэвсэг техникийн бэлэн байдлыг хангаж, авто техник хуягт танк зэрэг зэвсэглэлд сэргээн засварлах үйлчилгээг хийснийг ангийн захирагч хурандаа А.Болдбаатар онцолсон юм. Ташрамд дурдахад Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүхийн санаачлан өрнүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрт тус анги идэвхийлэн хамрагдаж Зүүнбаян цэргийн хүрээ болон говийн бүсэд ногоон байгууламжтай анги болохоор зорин ажиллаж байгаагаа ажлын хэсэгт танилцуулсан юм.

Дэслэгч О.ТӨРТӨГТӨХ



өмнөд хэсгийн агаарын орон зайд хяналт үйлдэж, тал нутгийн агаарын хилийг нүд цавчилгүй манан, хүлээсэн үүргээ нэр төртэй гүйцэтгэж байгаа 281 дүгээр салбарын

муудаж зуны улиралд дусаал гоожих, нурах эрсдэлд орсон, бие бүрэлдэхүүний 70 хувь нь 18-30 насны залуу боловсон хүчин эзэлж байгаа тул



НЭГ БҮРИЙН БЭЛТГЭЛ ШАТНЫ СУРГАЛТЫГ АМЖИЛТТАЙ ЯВУУЛЖ ДУУСЛАА



Зэвсэгт хүчний 189 дүгээр анги

2021-2022 оны цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу “Нэг бүрийн бэлтгэл шат”-ны сургалтыг ангийн бэлэн байдал болон сэтгэл зүйн бэлтгэлжилтийн түвшнийг дээшлүүлэн, техник технологийн дэвшлийг нэвтрүүлэх, сурах арга зүй, ухамсар, идэвхийг хөгжүүлэх замаар суралцагч төвтэй хөтөлбөрт суурилан 11 дүгээр сарын 1-30-ны өдрийн хооронд амжилттай зохион байгуулж явууллаа. “Нэг бүрийн бэлтгэл шат”-ны сургалтыг “Тактик, жагсаалын хичээл”-ээр эхлүүлэн сургуулийн буудлагыг нэг удаа

явуулсны дээр шалгалтын буудлагыг буудлагын төхөөрөмж ашиглан ангийн байрлалд явуулж, нийт 9 төрлийн хичээлээр 30 цагийн сургалтыг танхимаар зохион байгууллаа.

Тус сургалтын шатанд 60 км-ын явган маршийг 11 дүгээр сарын 19-ний өдөр ангийн байнгын байрлал-Баянзүрхийн товчоо-Туул тосгон-Харганатын ам-Төрхурхын амны чиглэлд амжилттай явуулсан нь цэргийн алба хаагчдын байлдааны үүрэг гүйцэтгэх бэлэн байдал, сургалт бэлтгэлийг эрчимжүүлэх, сэтгэл зүйн бэлтгэлжилтийг дээшлүүлэхэд чухал нөлөө үзүүллээ. Цаг агаарын хүндрүүлсэн нөхцөлд

бусдыгаа манлайлан алхаж маршийг тэргүүлсэн 5 цэргийн алба хаагчид ангийн дурсгалын зүйл болон талархлын бичгийг гардуулав.

Түүнчлэн ангийн бие бүрэлдэхүүний хоорондын уур амьсгал, гар нийлэмжтэй ажиллагаа, эх оронч үзлийг дээшлүүлэх зорилгоор 11 дүгээр сарын 11-ний өдөр Хүүхэд залуучуудын хөгжлийн төвтэй хамтран “Эх оронч залуу” сургалт, 11 дүгээр сарын 18-ны өдөр “Эерэг тэмүүлэл” ТББ-тай хамтран “Эерэг хандлага, харилцаа” сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулж явууллаа.

Дэслэгч С.СУВДАНЧИМЭГ



ХҮЧИТ 128 БӨХИЙН БАРИЛДААН БОЛОВ



Зэвсэгт хүчний 353 дугаар анги

Налайх дүүргийн аймгийн цол олгох хүчит 128 бөхийн барилдаан 11 дүгээр сарын 30-ны өдөр Зэвсэгт хүчний 350 дугаар

ангийн байрлалд зохион байгуулагдав.

Тус барилдаанд Зэвсэгт хүчний 353 дугаар ангиас аймгийн нэмэх начин С.Галданцогт,

аймгийн начин Ч.Асарсайхан тэргүүтэй 15 бөх зодоглосноос аймгийн нэмэх начин С.Галданцогт 7 даван түрүүлж, аймгийн арслан цол хүртлээ.



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ



ЦАХИМ ХАЯГ



Батлан хамгаалах яам



Зэвсэгт хүчний Жанжин штаб



ЦАХИМ ХУУДАС



“Соёмбо” сонин



“Дуулга” студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018

Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)